

ГУРВАН БАТТӨМӨРИЙН УЧРЫГ НЭХЭН ТОДРУУЛСАН МИНЬ

Х.Мөнхбаяр

ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний төв

Өгүүллийн товч утга: 1950-иад он хүртэлх хугацаанд Монголын албан баримтад хүний овог буюу эцгийн нэрийг бичдэггүй байснаас түүх бичлэгт адил нэртэй хүмүүсийг хооронд нь андуурах явдал гарах болсон. Үүний жишээ бол Баттөмөр хэмээх адил нэртнүүд юм. Тиймээс энэхүү судалгаагаар тэдгээр Баттөмөрийн учир ялгааг олж, хэн хэн болохыг тогтоолоо.

Түлхүүр үг: Баттөмөр, Сайн Ноён Хан аймаг, МАХН-ын Их Хурал, Намын Төв Хорооны Тэргүүлэгчид (НТХТ), хэлмэгдүүлэлт, цагаатгал.

XX зууны монголын түүхийн судалгаа нь 1990 оноос хойш түүх судлалын шинэ хандлага, аргазүйгээр эрчимтэй хөгжиж байна. Ардчилсан хувьсгал ялахаас өмнө манай шинжлэх ухаанд баримталж байсан марксист аргазүй Түүх судлалын шинжлэх ухаанд ч хүчтэй нөлөөлсөн бөгөөд тэрхүү марксист аргазүй нь түүхийг ангийн тэмцлийн онолын үүднээс тайлбарлаж, тэр утгаараа түүхийг бүтээгч нь ард түмэн хэмээн томъёолох болсон нь түүхэн дэх бие хүний үүргийг үгүйсгэж, түүхийг эзэнгүйдүүлэхэд хүргэж байсан билээ.

Тиймээс улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөж, Монголын түүхийг бодитойгоор боловсруулах эрэл хайгуулын дунд Түүхийн шинжлэх ухааны хавсарга ухаан болох Намтар судлалын ухаан хөгжиж ирэв. Энэ явцад доктор (Sc.D), академич Ж.Болдбаатар, доктор (Ph.D), профессор З.Лонжид болон бусад хэд хэдэн судлаач XX зууны Монголын төр, нийгмийн зүтгэлтнүүдийн намтар түүхийг судалж, дорвитой бүтээлүүдийг туурвисан юм.

Ийнхүү 1990 оноос хойш манай түүхчид намтар судлалаар нилээд олон бүтээл хэвлүүлж олны хүртээл болгосон юм. Гэвч олны сайн мэдэх буюу алдартай хүмүүсийн намтрын судалгаанд голлон анхаарч байгаагийн улмаас бусад түүхт хүмүүсийн намтрын судалгаа орхигдож ирсний сацуу зарим тохиолдолд эндүүрэл, ташаарал ч гарч байна. Тодруулж хэлбэл 1950-аад он хүртэлх хугацаанд төрийн албан хэрэг хөтлөхдөө хүний овог буюу эцгийн нэрийг бичдэггүй байснаас түүхийн судалгаанд адил нэртэй хүмүүс андуурагдан тэмдэглэх тохиолдол цөөнгүй байдаг. Жишээлбэл, 1920-1940-өөд онд манай түүхэнд Жамсран, Дэндэв, Гэндэн, Дорж, Дамба, Цэрэн, Чимид гэхчилэн тухайн үедээ түгээмэл байсан түвэд нэрс олонтаа тэмдэглэгдэж, тэр хэрээрээ одоо хүртэл эндүүрлийг үүсгэж байна.

Тийнхүү манай түүхэнд одоо ч андуурагдаж байгаа тийм хүмүүс бол Баттөмөр хэмээх ижил нэртнүүд юм. Тиймээс би XX зууны эхэн хагасын Монголын түүхэнд өөрийн ул мөрөө үлдээсэн эдгээр Баттөмөрийн тухай нэхэн өгүүлье.

Баттөмөр гэдэг нэрийг сонссон хэнбугайн ч санаанд 1930-аад онд БНМАУ-ын Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдаар ажиллаж байсан Цэндийн Баттөмөрийн тухай бодол орж ирдэг. Тэр ч утгаараа түүхийн эх сурвалжуудад нэр дурьдагдсан Баттөмөрийг Ц.Баттөмөр мөн хэмээн ойлгодог. Энэ нь ч аргагүй зүйл юм. Манай шинэхэн түүхэнд нэр нь тэмдэглэгдсэн хамгийн танил Баттөмөр бол одоогийн Баянхонгор аймгийн Заг сумын уугуул Ц.Баттөмөр юм. Энэ хүнийг бид “Үнэн” сонины эрхлэгчээр олон жил ажилласан БНМАУ-ын СГЗ Ц.Намсрай агсаны төрсөн ах, Ардын Жүжигчин Л.Цогзолмаагийн хадам ах, МУГЖ Н.Сувдын авга ах гэдгээр нь хүлээж авбал дөхөмтэй юм.



**Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд
Ц.Баттөмөр эхнэр Ц.Лхамжавын
хамт (1936 он)**

Гэвч өгүүлэн буй үеийн Монголын түүхэнд зөвхөн Цэндийн Баттөмөр хэмээх ганц Баттөмөр байсангүй. Харин бүр гурвын зэрэг Баттөмөр байжээ.

Юуны өмнө бидний хамгийн сайн мэдэх Ц.Баттөмөрийн тухай өгүүлье.

Цэндийн Баттөмөр 1904 онд тухайн үеийн Сайн ноён хан аймгийн Эрдэнэ Жанжин засгийн хошуу, одоогийн Баянхонгор аймгийн Заг сумын нутагт хар Цэндийн ахмад хөвгүүн болон мэндэлжээ. Тэрбээр амь зуухын эрхээр өсвөр насандаа чинээлэг айлуудад зарцлагдаж байгаад 1924 оны намар цэрэгт дайчлагдан нийслэл Улаанбаатар хотноо ирж Их бууны хороонд хуваарилагдан очсон байна. Тэр даруйдаа нам, эвлэлийн гишүүнд өөрийн сайн дураар элсэн оржээ.

Тэрээр 1924-1925 онд Монгол Ардын Хувьсгалт Цэрэгт цэрэг ба бага даргын алба хааж байгаад 1925 оны намраас 1926 оны зуны хооронд Цэргийн Ерөнхий Сургуулийн Нам ба Улс төрийн ангид суралцаж төгсөөд Их бууны хороонд улс төрийн удирдагчаар томилогджээ. Дараа нь Хан Хэнтий Уулын

аймгийн төвд шинээр байгуулж байсан Нутгийн дивизионд 1926 оны өвөл улс төрийн удирдагчаар шилжин очиж 1928 оныг хүртэл ажиллаж байгаад мөнөөх Их бууны хороондоо улс төрийн удирдагчаар эгэж ирсэн аж. Төд удсангүй мөн оны сүүлчээр Улаанбаатар хотын I морьт дивизийн I хорооны комиссараар томилогджээ. Тэндээсээ 1929 оны намар Баянтүмэн дэх V хорооны комиссараар шилжиж 1931 он хүртэл ажиллаж байгаад Цэргийн Улс Төрийн Газар (ЦУТГ)-т ирж Байгуулах хэлтсийн дарга бөгөөд ЦУТГ-ын даргын орлогчоор дэвшин ажиллаж, улмаар 1932 оны I-VII сард Дорнод аймгийн Намын Хорооны даргаар шилжин ажиллахын сацуу тус аймагт шинээр эмхлэгдэн байгуулагдсан МАХЦ-ийн II корпусын комиссарын үүргийг давхар гүйцэтгэж байв. “Шинэ эргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлсэн 1932 оны VII сард Улсын Бага Хурлаас Ц.Баттөмөрийг Ардыг Гэгээрүүлэх яамны сайдаар томилжээ. Тэрбээр 1934 оны хавар хүртэл АГЯ-ны сайдаар ажиллаж байгаад “Хувьсгалын Эсэргүү Лхүмбийн хэрэг”-т холбогдож мөн үеэс 1934 оны өвөл хүртэл ЗХУ-ын Москва хотод цөлөгдөж байгаад эх орондоо эргэн ирсэн байна. Улмаар 1936 оны эхэн хүртэл Хоршоонд Сурган боловсруулах хэлтсийн дарга, Алтанбулагийн баазын туслах болон даргын алба хааж байгаад олон нийтийн байгууллагад шилжиж, Улсыг батлан хамгаалах Зөвлөлийн даргаар түр ажиллав. Төд удалгүй 1936 оны II сарын сүүлчээр Эрүүлийг хамгаалахын сайдаар дэвшин ажиллаж байснаа Ардыг Гэгээрүүлэх яамны сайдад томилогдож 1937 оны IX сарын 10 хүртэл ажиллажээ. Тэрбээр 1936 онд Алтан гадас одонгоор шагнагдажээ.¹

Улмаар 1937 оны IX сарын 10-ны шөнө улс төрийн хэрэгт холбогдон баригдаж 1937 оны X сарын 21-ний өдөд БНМАУ-ын Дээд Шүүхийн 39 дүгээр хурлаас хилсээр шийтгүүлэн цаазлагджээ.² Харин БНМАУ-ын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх

¹ МУТЕГ-ын ТА. ХН-Ц-1030.

² ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс Төрийн Талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны Төв. “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал-Цагаан ном: II боть (Архангай аймаг)” /цохимол эх/. УБ., 1996. X-61.

Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны II сарын 13-ны өдрийн 80 дугаар тогтоолоор өмнө нь хэрэгт шийтгэгдсэн 14 хүнд холбогдох улс төрийн хэргийг хэрэгсэхгүй болгон нэр төрийг нь сэргээн цагаатгахад Ц.Баттөмөр цагаатгагджээ. Өдгөө түүний охин Л.Пагамдулам нийслэл Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн IV хороонд амьдарч байна. Бид түүнийг 1982-1991 онд Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны даргаар ажиллаж байсан гэдгээр нь эчнээ мэдэх билээ.

Ц.Баттөмөрийн улс төрийн оролцоог МАХН-ын болон Улсын Их Хурлуудад төлөөлөгчөөр сонгогдон суусан байдлаар тоймлон авч үзэж болох юм. Ц.Баттөмөр ажил амьдралын өрнүүн үедээ МАХН-ын V ба VI Их Хурлуудад төлөөлөгчөөр оролцож явсан төдийгүй 1930 онд хуралдсан БНМАУ-ын VI Их хурлаас Улсын Бага Хурлын гишүүнд³ сонгогдож байв. Мөн, Хоршооны VII Их Хуралд оролцсон аж.

Түүний хувьд Цэргийн ерөнхий сургуулийг төгсөөд Их бууны хороонд улс төрийн удирдагчаар томилогдон ажиллаад удаагүй байхдаа 1926 оны намар IX сарын 26-аас мөн оны X сарын 4-ны хооронд хуралдсан Намын V Их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцжээ. Тус хуралд оролцохоор МАХН-ын тухайн үеийн гишүүд болох 11600 хүнийг төлөөлсөн 243 төлөөлөгч сонгогдсноос 141 нь хүрэлцэн ирж суужээ.⁴ Хурлаас гадаад бодлогын талаар баримтлах намын чиг шугмыг тодорхойлж: “МАХН-аас бүх дэлхийн хувьсгалын явдал лугаа холбоог улмаар зузаатгаж, удирдлагыг хүлээсээр байх ба олон түмэн ард нь эрх чөлөөгөө олсон Зөвлөлийн Засагт Холбоот Улс лугаа аж ахуйн явдлаар туйлын бат холбоог байгуулах ба мөн цаашид ард түмнээ, эрх чөлөөгөө олсон бусад улсууд лугаа энэ мэт холбоо байгуулж бататгахыг эрмэлзэх...” болно гэж тэмдэглэжээ.⁵

Их хурал МАХН-ын эдийн засгийн бодлогыг улам боловсронгуй болгоход анхаарч, феодал ангийн эдийн засгийн хүчин чадлыг эвдэж устгах, капиталист элементийн өсөлтийг хязгаарлах, улс орны эдийн засгаас гадаадын капиталыг шахан зайлуулах, аж ахуйн байгуулалтыг ардын төрийн зүгээс удирдах явдлыг хүчтэй болгох явдлыг намын эдийн засгийн бодлогын зангилаа асуудал болгон дэвшүүлжээ.

Үүний хамт түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг боловсруулан зааж, эдийн засгийн гол салбарын хувьд мал аж ахуйг хөгжүүлэхдээ улсаас үзүүлэх туслалцааг өргөтгөж, ардын аж ахуйтанд зээл олгох, мал эмнэлэгийн газруудыг олшруулах, албан татаварын системийг улам боловсронгуй болгох талаар шийдвэр гаргажээ.

Хурлын явцад нам доторх баруун болон зүүн чиглэлийнхний үзэл санааны зөрөлдөөн ажиглагдаж байв. Намын удирдах хэсэг үндэсний ардчилсан үзэл санаатай байхад П.Гэндэн, Ө.Бадрах нарын нэг хэсэг нь үүнээс эрс өөр байр суурьтай байжээ. Тухайлбал: НТХ-ны нарийн бичгийн дарга Ц.Дамбадорж: “...энэ завсар хар харгис (ноёд язгууртнууд-Х.М) нам лугаа тэмцэлдэх хүчин бус болжээ... хуучин харгисын хүчин нэгэнт мөхсөн” хэмээж байсан бол “Баруунтан”-ы үзэл сурталч гэгдэж байсан Ж.Цэвээн: “Манай намын зорилт, бурхны номын гол зорилт хоёр олон түмний тусын тулд хандуулсан тул харшлах явдалгүй, харин чнийлэлцэх зүйл буй учир ... дэмий хувьсгалт сүр үзүүлэн буруу ухаж, намын суртал, төрийн бодлого шашин лугаа харш мэт хэмээн чалчин явбаас их л мунхагдан ташаарч олны саналыг алдагдуулахад хүрнэ”⁶ гэж хэлж байв.

Ц.Дамбадорж, Ж.Цэвээн нараас: “Манай намын гишүүд өөрийн ажлаа боловсронгуй сайнаар явуулж бусад ард олныг хоосруулахгүй, нийтдээ хэм тэгш хөрөнгөжихийг хичээх хэрэгтэй” гэсэн агуулгатай “Баяжигтун” лоозунг дэвшүүлсэн⁷

³ МУУТА. Ф-11, Д-1, ХН-225

⁴ “МАХН-ын V Их Хурал”. УБ., 1981. Тал-4, 7.

⁵ “МАХН-ын V Их Хурал”. УБ., 1981. Тал-3.

⁶ “МАХН-ын V Их Хурал”. УБ., 1981. Тал-5

⁷ Мөн тэнд.

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

боловч Коминтернийг аялдан дагалдагч П.Гэндэн нарын ятгалганд автсан гишүүдийн олонх нь хүлээж аваагүй билээ.

Эл хурлын төлөөлөгчдийн бүртгэлд цэргийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт байхгүйн дээр санал шүүмжлэл өрнүүлсэн хүмүүсийн дунд Ц.Баттөмөрийн нэр байхгүй байна. Гэвч түүний өөрийн гараар бичиж үлдээсэн гурван үеийн түүх болон 1937 онд хилс хэрэгт мөрдөгдөж байхдаа мэдүүлсэн анхны мэдүүлэг зэрэгт “Намын V Их Хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцсон” гэж тэмдэглэсэн байдгаас үзэхэд Ц.Баттөмөр дээр их хуралд оролцсон нь тодорхой юм. Харин тэрбээр залуу шинэ хүний хувьд эл хуралд ажиглагчийн байр сууринаас хандаж, улс төрийн том сургууль туршлагад суралцаж байсан байх. Энэ үед МАХЦ-ийн дотор намын гишүүд 2429 болж өмнө оныхоос 524 хүнээр нэмэгджээ.⁸

Ц.Баттөмөр Намын V Их хуралд оролцсоны дараа жил нь 1927 оны IX сарын 22-ноос X сарын 5-ныг дуустал хуралдсан МАХН-ын VI Их хуралд мөн төлөөлөгчөөр сонгогдон оролцжээ. Тус хуралд тухайн үеийн МАХН-ын эгнээнд байсан 11587 гишүүн, орлогч гишүүдийг төлөөлсөн 172 төлөөлөгч оролцсон байна.⁹ Гэвч төлөөлөгчдийн бүртгэл хадгалагдан үлдсэнгүй. Харин мандатын комиссын илтгэл бололтой 140 гаруй хүний нэрсийн жагсаалтад хадгалагдан үлдсэн¹⁰ бөгөөд эл жагсаалтын № 107-д Баттөмөр гэсэн нэр бичигдсэн нь Ц.Баттөмөр мөн болно.

Ц.Баттөмөр өмнө нь МАХН-ын V Их хуралд санал, шүүмжлэл гаргалгүй, ажиглагчийн байр сууринаас оролцож байсан бол намын VI Их хуралд идэвхитэй оролцжээ. Энэ нь түүнийг улс төрийн байр суурийн хувьд төлөвшиж эхэлснийг харуулж байна. Тэрбээр хуралдааны зургаадугаар өдөр буюу IX сарын 27-ны үдээс өмнөх хуралдаанд НТХ-ны болон зохион байгуулах тухай илтгэлд шүүмжлэл гаргажээ. Ц.Баттөмөр:- “Хоршоо, мал эмнэлэгийн явдал сайнгүй хэмээх, үүнд хянаваас, тэдгээр газруудад их төлөв гадаадын хүмүүс үлэмжхэн байхаас харилцсанд хэл нэвтрэлцэхгүй энэ ийнхүү сайжирч чадсангүйн дээр эдгээр дарга нарыг хуралдуулж илтгэлийг сонсож, зааврыг өгч гүйцэлдүүлвээс дөхөмтэй мэт.

Бас нутгийн ардууд ган гачигт тохиолдож өөр өн талбиу газар нүүдэллэн очиход хөөх зэргээр гачигдуулах гэм буй тул энэ тухай тусгай дүрэм гаргаж, аль бололцохоор нутаглуулах болговоос зохих мэт.

Бас аливаа нягтлан бодоход боловсорсон хүнгүйгээс тэгшитгэсэн татвар, гаалийн (гааль-Х.М) зэрэгт хэрэгт алдагдал гарах болзошгүй тул тусгай хүмүүсийг боловсруулан гаргах зэргээр хянах нягтлах хэрэгт боогдолгүй болгохыг оролдвоос зохино. Бас дотоодын гаалийг хорогдуулахын дотор ялангуяа тус улсад будааны зүйл ховор бөгөөд ядуу ардуудаас идэх будааг олох учраа гадаадад явахад мөн тэднээс дотоодын гааль хураах нь хэцүү боогдолтой зүйл буй тул ялангуяа энэхүү зэргийн хэргийг хэлтрүүлбээс зохих болов уу. Бас сургуулийн наснаас хэтэрсэн залуучуудыг тус тусын орон нутгийн газруудад хуралдуулан тусгай үүрэг хүлээлгэхгүй, бичиг үсгийн албанд туслалцуулбаас зохих болов уу хэмээн санах тул хоршооны сургуулийг идэвхийлэн сургагчид уг албан ажлаас эрхлүүлэхийг чухалчилбаас зохих болов уу.

Бас ший жүжгийг урьд хөдөө газар хэсүүлэн явуулахаар буй нь зүйтэй. Хөдөөгийн үүрийн тэргүүлэгчдийн зарим нь дарга нарын сургуульд үл ирэх нь буй тул үүнээс урагш эрх биш жинхэнэ тэргүүлэгчдийг ирүүлж байваас зохих болов уу”¹¹ хэмээн санал гаргажээ.

Мөн хурлын найм дахь өдрийн оройн хуралдаанд буюу IX сарын 28-нд Ц.Баттөмөр Намын Хянан байцаах төв комиссын илтгэлд шүүмжлэл гаргаж:- “Гишүүдийн чанар

⁸ “МАХН-ын V Их Хурал”. УБ., 1981. Тал-101.

⁹ “МАХН-ын VI Их Хурал”. УБ., 1980. Тал-3.

¹⁰ “МАХН-ын VI Их Хурал”. УБ., 1980. Тал-262.

¹¹ “МАХН-ын VI Их Хурал”. УБ., 1980. Тал-131, 132.

байдлыг шинжилсэн дэвтрийг зохиож гаргахыг завдан буй хэмээсэнд хянаваас, харъяат төв комисс хуучин шалгалтаас хоцрогдсон гишүүд хэд болох ба мөн хөөгдөгсдийн дотор эмэгтэйчүүд оролцсон эссэн зэргийг өнөө мэдэхгүй байгааг үзхүл тэр дэвтэр тийм сайн чанартай болсон хэмээхэд эргэлзэлтэй байна. Бас тус намын гишүүдийн дотор таван зуун янчаанаас илүү цалин авдаг этгээд байна уу хэмээн асуухад байхгүй болов уу хэмээн таавар хариулсан нь хойшид нарийн мэдэж эрс тэс хэлж байваас зохино”¹² гэж шүүмжилсэн байна. Чингэж тус хурал дээр Ц.Баттөмөр аливаа зарчимч, эрс шулуун нэгэн болохоо харуулж, нам, төрийн зүтгэлтнүүдийн дунд эзлэх байр сууриа тодорхойлжээ гэж үзэж болох юм.

Ц.Баттөмөр ийнхүү Хоршооны VII, МАХН-ын V ба VI, БНМАУ-ын VI Их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцож байсны дээр Улсын Бага хурлын гишүүнд сонгогдон ажиллаж байлаа.

Энд нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд судлаачид Ц.Баттөмөрийг МАХН-ын III болон IV Их Хурлуудад оролцсон гэж тэмдэглэсэн байдаг. Тухайлбал судлаач Г.Дүйнхэржав:- Намын III “Их хурлын дарга Н.Насанбатаас С.Данзан, Ж.Баваасан, С.Буяннэмэх, Б.Доржпалам нарыг дайчлан баривчлах тухай санал хураахад төлөөлөгчид баривчлах нь зүйтэй гэснээр тэднийг баривчлах үүргийг Дотоодыг Хамгаалах газрын дарга К.К.Баторунд өгснөөс тэднийг хууль ёсоор баривчилжээ. Ингээд тэдний хэргийг шүүх Засгийн газрын комисс байгуулан түүндээ Ц.Баттөмөр, Н.Гонжоон, Д.Лосол, Гомбожав, Н.Түвшинтөр, Н.Насанбат, Гончиг нарыг томилжээ”¹³, “Монгол Ардын Намын III Их хурал дээр Э.Ринчино болон хурлын тэргүүлэгчдийн зүгээс С.Данзангийн хэргийг тусгай комисс томилон 24 цагийн дотор шалган шийдвэрлэх нь зүйтэй гэдэг санал оруулсны үндсэн дээр бүрэн эрхтэй тусгай комисст Шүүх яамны эрхэлсэн түшмэл Н.Түвшинтөр, комиссар Н.Насанбат, Ц.Баттөмөр, Н.Гонжоон, Д.Лосол, Гомбожав, Гончиг нарыг томилон ажилуулсан боловч тэдний юу хийсэн нь тодорхойгүй байна”¹⁴ гэж бичжээ.

Гэтэл Ц.Баттөмөр 1924 болон 1925 оны эдгээр хурлуудад огт оролцоогүй бололтой. Учир нь тэрбээр дээрх хурлуудад оролцсон тухайгаа нэг ч удаа тэмдэглэж байгаагүйн дээр энэ үед цэрэгт цэрэг, Цэргийн Ерөнхий сургуульд сурагч байсан. Энэ нь түүнийг намын III болон IV Их Хурлуудад оролцоогүй, оролцох боломжгүй байсныг харуулж байна.

МАХН-ын III болон IV Их хуралд оролцсон Баттөмөр гэгч хэн байв? Баримт түшин үзье.

1924 онд хуралдсан Намын III Их хурлын баримтыг нягтлахад төлөөлөгч 112 хүний нэрсийн жагсаалтанд Баттөмөр гэдэг хүний нэр байхгүй байгаа боловч хуралд зөвлөх эрхтэй суусан НТХ-ны гишүүд ба удирдах хүмүүсийн бүртгэлийн №3-т “Баттөмөр-төлөөний түшмэлийн төлөөлөгч”¹⁵ гэж бичигдсэн байх бөгөөд тэрбээр уг хурлаас НТХ-ны гишүүнээр сонгогдож 1926 он хүртэл ажиллажээ¹⁶.

Мөн МАХН-ын IV Их Хурлын баримтанд буй төлөөлөгч 190 хүний нэрсийн жагсаалтанд Баттөмөрийн нэр байхгүй байгаа боловч хурлын 7 дугаар өдөр НТХ-ны

¹² “МАХН-ын VI Их Хурал”. УБ., 1980. Тал-174.

¹³ Дүйнхэржав Г. “Содномбалжирын Буяннэмэхийн улс төрийн намтар”. УБ., 1997. Тал 27., ЦАУЗБУК-ийн дэргэдэх Улс төрийн талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны төв. “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон (V боть)”. УБ., 2006. Тал 45.

¹⁴ Дүйнхэржав Г. “Наваандоржийн Насанбатын улс төрийн намтар”. УБ., 1997. Тал 13., ЦАУЗБУК-ийн дэргэдэх Улс төрийн талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны төв. “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон (IV боть)”. УБ., 2006. Тал 136.

¹⁵ “Монгол Ардын Намын III Их хурал”. УБ., 1966. Тал 236.

¹⁶ “Монгол Ардын Намын III Их хурал”. УБ., 1966. Тал 257., “МАХН-ын IV Их хурал”. УБ., 1978. Тал 308.

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

гишүүнд 35 хүнийг сонгосны дотор “Цэцэрлэг мандал аймгийн Баттөмөр”¹⁷ хэмээн тэмдэглэгдснээс үзэхэд энэ хүн тус хуралд мөн зөвлөх эрхтэй оролцсон бололтой.

Эндээс үзэхэд 1924-1926 онд НТХ-ны гишүүнээр ажиллаж байсан Цэцэрлэг Мандал аймгийн төлөөний түшмэл бол Ц.Баттөмөр биш болох нь ийнхүү нотлогдож байна. Тэгвэл судлаачдын дээрх хурлуудад суусан гэж ташаараад буй Баттөмөр гэж хэн бэ?

Судлаач миний бие эрдэм шинжилгээний эрэл хайгуулын дүнд энэхүү Баттөмөрийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн, Гонгорын Баттөмөр мөн болохыг тогтоосон. Үүний нотолгоо бол хилс хэрэгт мөрдөгдөж байхдаа түүний мэдүүлсэн биеийн байцаалт юм.



Тэрбээр:- “...13 наснаас 33 нас хүртэл Цагаан сүмийн хийдэд шавилан лам байгаад 1922 онд хар болж намын төлөөлөгч ба намын Бүгд хурлын гишүүн хэмээн явж байгаад 1925 онд намын дотор хагарал тэмцлийн зэрэг үл бүтэх байдал гаргасан учраас намын гишүүнээс ба Бүгд хурлын гишүүнээс хөөгдөж, түүнээс хойш хоршоо, хамтралын газар бага зэрэг ажиллаж сүүлийн үед хөдөө гэр малын ажил хийж явсан”¹⁸ гэж мэдүүлсэн байдаг.

Гонгорын Баттөмөр гэж хэн бэ? Тэрбээр 1887 онд

Зүүн гар талаас: Өвөр эгнээнд 1. Ө.Бадрах, 2. Х.Чойбалсан, 3. А.Амар, 4. Н.Жадамба, 5. Б.Цэрэндорж. Арын эгнээнд 1. Г.Баттөмөр, 2. Н.Хаянхярваа, 3. С.Магсаржав, 4. Ц.Гэлэгсэнгэ нар (1925 оны орчим)

Хуучнаар халхын Сайн ноён хан аймгийн Ачит гүнгийн хошуу, 1930-аад оны Архангай аймгийн Өндөрсант сум, одоогийн мөн аймгийн Түвшрүүлэх болон Цэнхэр сумдын зааг нутагт ард Гонгорын хоёрдугаар хөвгүүн болон мэндэлжээ. Тэрбээр 13 наснаас 33 нас хүртэл хуврагийн мөр хөөж, нутгийхаа Цагаан сүмийн хийдэд шавилан сууж байгаад 1922 онд хар болж Монгол Ардын Намын гишүүнд элссэн байна. Улмаар Цэцэрлэг Мандал Уулын аймаг дахь МАХН-ын Төв Хорооны төлөөлөгчөөр томилогдон ажиллахын зэрэгцээ Дотоодыг Хамгаалах Газарт алба хашиж байв. Тэрбээр 1924 онд VIII Богд Живзундамба хутагтын хөрөнгийг хураах комиссын гишүүнд, мөн онд хуралдсан МАН-ын III Их хурлаас С.Данзан нарын хэргийг шүүх Засгийн комисст тус тус томилогдон ажилласны сацуу энэхүү III Их Хурал болон 1925 онд хуралдсан МАХН-ын IV их хурлуудаас НТХ-ны гишүүнд сонгогдсон аж. Тэрбээр тухайн үед олон түмний дунд “баруун” Баттөмөр гэдэг нэрээр алдаршиж, танил болжээ.

Гэвч “Намын дотор хагарал тэмцлийн зэрэг үл бүтэх байдал гаргасан” гэдэг шалтгаанаар 1925 онд намын анхдугаар шалгалтаар намаас хөөгдөж, түүнээс хойш хоршоо, хамтралын газар бага зэрэг ажиллаж сүүлийн үедээ хөдөө гэр малын ажил хийж яваад 1938 оны 3 сарын 9-нд улс төрийн хэрэгт холбогдон баривчилагдаж, 1938 оны XI

¹⁷ “МАХН-ын IV Их хурал”. УБ., 1978. Тал 279, 281.

¹⁸ МУТЕГ-ын ТА. Ф-1, Д-24, ХН-Ц-3659. Х-6.

сарын 19-нд ОБЭЖ-ийн 19 дүгээр хурлаас буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэгджээ. Түүнд холбогдуулсан хэрэг хилс болохыг тогтоож МУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн 1992 оны VII сарын 6-ны өдрийн 109 дүгээр магадлалаар нэр төрийг нь сэргээн цагаатгасан.¹⁹ Эдүгээ түүний охин Я.Пунцагдулам Архангай аймгийн Эрдэнэбулган суманд амьдарч байна.

Түүнчлэн Ц.Баттөмөрт холбогдох бас нэгэн эндүүрэл байдаг. Энэ хүнийг МАХН-ын Баримтын Төвд буй Хүний нэрийн заагуурын Б үсгийн хайрцагт:

“НТХТ-ийн 1937 оны 63 дугаар хурлын I зүйлд Худалдаа, Үйлдвэрийн яамны дэд сайдаар Сангийн Яамны Баттөмөрийг томилсон тухай: Цэндийн Баттөмөр” гэж тэмдэглэгджээ.

Архивуудад буй эх сурвалжаас үзэхэд НТХТ-ийн дээрх 63 дугаар хурал 1937 оны X сарын эхээр хуралдсан байна. Гэтэл Ц.Баттөмөр энэ үед ДЯЯ-ны хорих ангид хоригдож, харгис байцаалтын дор үйл тамаа үзэж байсан билээ.

Эндээс дүгнэхэд 1930-аад оны сүүлчээр БНМАУ-ын төрд бас нэгэн Баттөмөр хүчин зүтгэж явсан нь мэдэгдэж байна. Энэ хүн хэн бэ? 1937 оны сүүлчээс Худалдаа,

Үйлдвэрийн Яамны дэд сайдаар ажиллах болсон хүн хэн байв? Тэр хүн бол Жигмэдийн Баттөмөр юм.

Ж.Баттөмөр 1909 онд хуучнаар Сайн Ноён Хан аймгийн Илдэн бэйлийн хошуу, тухайн үеийн Архангай аймгийн Өндөрсант сум, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын нутаг Гурван хамар хэмээх газар мэндэлжээ. Түүний эцэг Жигмэд нь модны дарх хийдэг жирийн нэгэн ард байв.

Тэрбээр багын ухаан сэргэлэн хүүхэд байсан тул бичиг номд чамбай суралцаж, албаны мөр хөөх болжээ. Сангийн яамны дэргэдэх Санхүүгийн сургууль төгсөөд 1934 онд Архангай аймгийн Намын Хорооны Хянан Байцаах Комиссын гишүүнээр ажиллажээ. Улмаар 1935 онд Архангай аймгийн яамны Санхүүгийн хэлтсийн даргаар дэвшиж, дараа нь 1936, 1937 онуудад Сангийн яаманд байцаагчийн алба хашиж байв.²⁰

Харин Ж.Баттөмөр 1937 оны X сарын 7-ны өдөр хуралдсан МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 63 дугаар хурлаас Худалдаа, Үйлдвэрийн яам (сүүлдээ Худалдаа, Тээврийн Яам болж өөрчлөгдсөн-Х.М)-ны дэд сайдаар



**Худалдаа, Тээврийн Яамны
дэд сайд Ж.Баттөмөр
(1939 оны орчим)**

томилогджээ.²¹ Гэвч 1940 оны үед тодорхойгүй шалтгаанаар түүнийг албан тушаалаас нь халсан байна.

Ийнхүү түүнийг Улаанбаатар хотод ажилгүй, энгийн сууж байхад нь ДЯЯ-ны жинхэн орлогч сайд, II комиссар Жамбалдоржийн баталсан № 126 тоот ордероор 1940 оны X сарын 31-нд тус яамны ажилтан Дамдинсүрэн, Осоржав, Вандан нар улс төрийн хэрэгт дайчлан баривчилж, 1941 оны III сарын 5 хүртэлх хугацаанд 10 гаруй удаа мөрдөн

¹⁹ ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс Төрийн Талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны Төв. “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал-Цагаан ном: II боть (Архангай аймаг)” /цохимол эх/. УБ., 1996. X-61.

²⁰ МУТЕГ-ын ТА. ХН-Ц-1118-1, X-15, 146.

²¹ МАХН-ын Баримтын Төв. Ф-4, Д-6, ХН-10, X-64.

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

байцааж, МАХН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга байсан З.Баасанжавын удирдаж байсан гэх хувьсгалын эсэргүү “Төв” хэмээх байгууллагын идэвхитэй гишүүн болохыг нь “илрүүлжээ”.

Тиймээс 1941 оны X сарын 24-нд БНМАУ-ын Дээд Шүүхийн таслан шийтгэх 90 хурлын тогтоолоор Ж.Баттөмөрт хуулийн дээд хэмжээ ноогдуулсныг 1965 оны VII сарын 27-нд Дээд Шүүхийн дэргэдэх Тусгай Комиссын 072 тоот магадлалаар түүнд холбогдуулсан хэргийг хэрэгсэхгүй болгож, нэр төрийг нь цагаатгажээ.²²

Одоо Ж.Баттөмөрийн охин Д.Ундрах нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороонд амьдарч байна.

Ийнхүү манай шинэхэн түүхэнд тэмдэглэгдсэн Баттөмөрүүд бол Гонгорын Баттөмөр, Цэндийн Баттөмөр, Жигмэдийн Баттөмөр нар болох нь тодорч байна.

Түүнчлэн тэдгээр Баттөмөрүүдийг түүхийн хэдэн сонин тохиол хооронд холбож, төс бүхий хувь тавилан уялдуулж байгаа нь ажиглагдлаа.

1. Эдгээр Баттөмөр бол бүгдээрээ хуучнаар Сайн ноён хан аймгийн уугуул хүмүүс байв. Ц.Баттөмөр Сайн Ноён хан аймгийн Эрдэнэ Жанжин засгийн хошууны хүн бол Г.Баттөмөр мөн аймгийн Ачит гүний хошууны харъяат, Ж.Баттөмөр нь мөн аймгийн Илдэн бэйлийн хошууны унаган хүү байжээ.
2. Нэг Баттөмөр нь амжилт олж эхлэх үед нөгөөх нь ажил, амьдралын гараагаа эхэлж байжээ. Үүнд:
 - Г.Баттөмөр 1924 оноос эхлэн нам болоод төрд нөлөө бүхий суурь эзэл байх үед Ц.Баттөмөр дөнгөж цэрэгт дайчлагдан ирээд байв.
 - 1925 онд болсон МАХН-ын анхдугаар шалгалтаар Г.Баттөмөр намаас хөөгдөж, 1926 он гэхэд өөрийн улс төр, нийгмийн байр сууриа алдаад байсан бол мөн оны IX сард хуралдсан МАХН-ын V Их хуралд Ц.Баттөмөр төлөөлөгчөөр оролцож, өөрийн улс төрийн тэмцлээ эхлүүлж байжээ.
 - 1934 оны хавар Ц.Баттөмөрийг ЗХУ-ын Москва хотод албан хэргээр явж байхад нь Лхүмбийн хэрэгт холбогдуулан тэнд нь цөлж, төрийн эсрэг хэрэгтэнд тооцож байх үед Ж.Баттөмөр Санхүүгийн сургуулийг төгсөж, Архангай аймгийн Намын Хороонд ажиллаж эхэлжээ.
 - Ц.Баттөмөрийг 1937 оны сүүлээр улс төрийн хилс хэрэгт баривчлагдсаны дараахан Г.Баттөмөр Худалдаа, Тээврийн Яамын дэд сайдад томилогджээ.
3. Баттөмөрүүд бүгд БНМАУ-ын төр засагт хариуцлагатай алба хашиж, Монголын төлөө хүч чадлаа дайчлан зүтгэж иржээ.
4. Баттөмөрүүд бүгдээрээ улс төрийн хэргээр баривчлагдаж цаазлуулсан бөгөөд сүүлд энэ нь улс төрийн хилс хэрэг болох нь тогтоогдож, нэр төр нь цагаатгагджээ.
5. Тэд улс төрийн хилс хэрэгт баригдахынхаа өмнө ямар нэгэн байдлаар улс төрийн гадуурхалд өртөж байв.
 - Г.Баттөмөр “Намын дотор хагарал тэмцлийн зэрэг үл бүтэх байдал гаргасан” гэдэг шалтгаанаар 1925 онд МАХН-ын эхний шалгалтаар намаасаа хөөгдсөн. Энэ нь түүнийг барууны үзэл баримталж байсантай холбоотой бололтой.
 - Ц.Баттөмөр 1934 онд Лхүмбийн хэрэгт холбогдож, ЗХУ-д цөллөгт байсан. Зарим үед П.Гэндэнгийн үзэл бодолд шүүмжлэлтэй хандаж байсантай энэ асуудал холбогддог.
 - Ж.Баттөмөр 1940 оны эхээр эрхлэж байсан дэд сайдын албан тушаалаас зайлуулагдаж, ажилгүй сууж байсан. МАХН-ыг өөрийн гар доорх хүчин болгох гэсэн эрмэлзэлд нь гол саад болж байсан НТХ-ны Нарийн бичгийн

²² ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс Төрийн Талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны Төв. “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал-Цагаан ном: II боть (Архангай аймаг)” /цохимол эх/. УБ., 1996. X-61.

дарга агсан З.Баасанжавтай Ж.Баттөмөр дотно холбоотой байсан нь эл асуудлыг учиг аж.

6. Баттөмөрүүд бүгд тус бүр нэг охинтой байсан байх ба тэд нь одоо энх тунх амьдарч байна.

1920-1940-өөд оны үеийн Монголын сэхээтэн Г.Баттөмөр, Ц.Баттөмөр, Ж.Баттөмөр нарыг түүхч, судлаачид, сэтгүүлчид нэг хүн мэтээр ташаарч байсныг нэхэн тодруулахад ийм буюу.

Сайн ноён ханы Баттөмөрүүдийн тухай энэхүү судалгаа нь 1921 оноос хойшхи Монголын түүхийн судлал ба түүх бичлэг дэх зарим нэгэн эндүүрэл ба тодорхойгүй байдлыг арилгахад бага ч атугай тус дөхөм болохын дээр энэ мэтчилэн андуурагддаг адил нэртэй хүмүүсийн тухай шинжлэлд түлхэц өгөх буй за гэдэгт итгэлтэй байна.

Жич: 1921 оноос хойш манай түүхэнд ижил нэртэй хүмүүс цөөнгүй байжээ. Тухайлбал Лхамсүрэнгийн Дэндэв, Насангийн Дэндэв, Өлзийбаярын Дэндэв хэмээх гурван Дэндэв, Солийн Данзан, “япон” Данзан, “бага” Данзан зэрэг долоон хүн байдгийн заримынх нь учрыг одоо ч бүрэн олоогүй байдгийг цаашид нэхэн тодруулах талаар анхааруштай.

Abstract

In historical research, people who have same named had been misidentified because of one's surname wasn't written in official document of Mongolia until 1950. Example of these is people who named Battumur. Therefore, this research was conducted to find out differences between those Battumurs and it was found out that there were three Battumurs, Battumur Gongor of full fower representative of the Mongolian People's Revolutionary Party, Battumur Tsend of minister of the Mongolian People's Culture, and Education, and Battumur Jigmed of vice-minister of the Mongolian Trade and Transportation.

Ном зүй

1. Дүйнхэржав Г. “Наваандоржийн Насанбатын улс төрийн намтар”. УБ., 1997.
2. Дүйнхэржав Г. “Содномбалжирын Буяннэмэхийн улс төрийн намтар”. УБ., 1997.
3. “Монгол Ардын Намын III Их хурал”. УБ., 1966.
4. “МАХН-ын IV Их хурал”. УБ., 1978.
5. “МАХН-ын V Их Хурал”. УБ., 1981.
6. “МАХН-ын VI Их Хурал”. УБ., 1980.
7. МАХН-ын Баримтын Төв. Ф-4, Д-6, ХН-10.
8. МУТЕГ-ын ТА. ХН-Ц-1030.
9. МУТЕГ-ын ТА. Ф-1, Д-24, ХН-Ц-3659.
10. МУТЕГ-ын ТА. ХН-Ц-1118-1.
11. МУУТА. Ф-11, Д-1, ХН-225.
12. ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс Төрийн Талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны Төв. “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал-Цагаан ном: II боть (Архангай аймаг)” /цохимол эх/. УБ., 1996.
13. ЦАУЗБУК-ийн дэргэдэх Улс төрийн талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны төв. “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон (V боть)”. УБ., 2006.
14. ЦАУЗБУК-ийн дэргэдэх Улс төрийн талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны төв. “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон (IV боть)”. УБ., 2006.